

**“НИЙГМИЙН АРДЧИЛАЛ”  
МОНГОЛЫН ОЮУТНЫ ХОЛБООНЫ  
ДҮРЭМ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
Нийтлэг үндэслэл**

**1 дүгээр зүйл. Ерөнхий зүйл**

- 1.1 Энэхүү дүрмийн зорилго нь “Нийгмийн ардчилал” Монголын Оюутны Холбоо /цаашид “Нийгмийн ардчилал” МОХ гэх/-ны эрхэм зорилго, үйл ажиллагааны зарчим, үндсэн чиглэл, зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн эрх үүрэгтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 “Нийгмийн ардчилал” МОХ нь Монгол Ардын Намын дэргэдэх оюутны, нийгэмд үйлчилдэг, ашгийн бус, төрийн бус үндэсний хэмжээний гишүүнчлэлтэй байгууллага мөн.
- 1.3 “Нийгмийн ардчилал” МОХ нь Монгол Улсын хууль тогтоомж, Монгол Ардын Намын дүрэм, энэхүү дүрэм, тэдгээртэй нийцүүлэн гаргасан журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.
- 1.4 “Нийгмийн ардчилал” МОХ нь хавсралт 1-ээр батласан загварын дагуу бэлгэдэл, тугтай байна.
- 1.5 “Нийгмийн ардчилал” МОХ нь тэмдэг, харилцах данс, хэвлэмэл болон цахим хуудастай байна.
- 1.6 “Нийгмийн ардчилал” МОХ-ны удирдлагын төв нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Монгол Ардын Намын төв байр “Тусгаар тогтнолын ордон”-д байрлана.

**2 дугаар зүйл. “Нийгмийн ардчилал” МОХ-ны эрхэм зорилго, уриа, үнэт зүйлс, үйл ажиллагааны зарчим, үндсэн чиглэл**

- 2.1 **Эрхэм зорилго:**  
Нийгмийн ардчилсан үзэл санаанд тулгуурлан Монгол Улсын тусгаар тогтнол, эрх чөлөө, шударга ёс, эв нэгдэл, үндэсний язгуур эрх ашгийг эрхэмлэн дээдэлж, улс орондоо хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлоон байгуулахад оюутан залуусын хүсэл эрмэлзлэл, зорилгод тулгуурласан оролцоог хангах;
- 2.2 **Уриа:**  
Эрдэм, эвийн хүчээр ирээдүй өөд хамтдаа;
- 2.3 **Үнэт зүйлс:**
  - 2.3.1 Эрдэм мэдлэг;
  - 2.3.2 Гэр бүл, хайр;
  - 2.3.3 Үндэсний эрх ашиг;
  - 2.3.4 Уламжлалт хэл, соёл;
  - 2.3.5 Даян дэлхийн энх тайван;
- 2.4 **Үйл ажиллагааны зарчим:**
  - 2.4.1 Тэгш эрх, нийтийн оролцоо;
  - 2.4.2 Хүний эрх, эрх чөлөө;
  - 2.4.3 Ил тод, нээлттэй байдал;
  - 2.4.4 Эв нэгдэл, хамтын ажиллагаа;
  - 2.4.5 Ардчилал, шударга ёс;
- 2.5 **Үйл ажиллагааны үндсэн чиглэл:**
  - 2.5.1 Нийгмийн ардчилсан үзэл санааг түгээн дэлгэрүүлэх;
  - 2.5.2 Оюутны оюуны болон бие бялдарын хөгжлийг дэмжих;
  - 2.5.3 Монгол Ардын Намын бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оролцох;
  - 2.5.4 Оюутан залуусын нийгмийн идэвхи оролцоог өргөжүүлэх;
  - 2.5.5 Эх орныхоо хөгжил, бүтээн байгуулалтанд хувь нэмэр оруулах;
  - 2.5.6 Оюутан залуусын нөхөрлөл, сүлжээ байгуулах;
  - 2.5.7 Гадаад, дотоод хамтын ажиллагааг идэвхижүүлэх;

**ХОЁРДУГААР БҮЛЭГ  
Зохион байгуулалт, бүтэц**

**3 дугаар зүйл. “Нийгмийн ардчилал” МОХ-ны зохион байгуулалт, бүтэц**

- 3.1 **“Нийгмийн ардчилал” МОХ дараах бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулна.**
  - 3.1.1 “Нийгмийн ардчилал” МОХ-ны Их хурал;
  - 3.1.2 “Нийгмийн ардчилал” МОХ-ны Бодлогын зөвлөл;
  - 3.1.3 “Нийгмийн ардчилал” МОХ-ны Ерөнхийлөгч;
  - 3.1.4 “Нийгмийн ардчилал” МОХ-ны Бага хурал;
  - 3.1.5 “Нийгмийн ардчилал” МОХ-ны Удирдах зөвлөл;

- 3.1.6 “Нийгмийн ардчилал” МОХ-ны салбар;
- 3.1.7 “Нийгмийн ардчилал” МОХ-ны дэргэдэх зөвлөл

#### **4 дүгээр зүйл. “Нийгмийн ардчилал” МОХ-ны Их хурал**

- 4.1 “Нийгмийн ардчилал” МОХ-ны Их хурал /цаашид “Их хурал” гэх/ нь “Нийгмийн ардчилал” МОХ-ны эрх барих дээд байгууллага мөн.
- 4.2 Ээлжит Их хурал дөрвөн жилд нэг удаа хуралдана. Шаардлагатай үед ээлжит бус Их хурлыг энэхүү дүрэмд заасны дагуу зарлан хуралдуулж болно.
- 4.3 Их хурал “Нийгмийн ардчилал” МОХ-ны аймаг, нийслэл, дүүргийн бүх салбар болон их дээд сургууль, коллеж, МСҮТ-ын оюутан зэрэг төлөөллөөс бүрдэнэ.
- 4.4 Их хурал нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 4.4.1 “Нийгмийн ардчилал” МОХ-ны үзэл баримтлал, бодлого тодорхойлох;
  - 4.4.2 “Нийгмийн ардчилал” МОХ-ны дүрмийг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах;
  - 4.4.3 “Нийгмийн ардчилал” МОХ-ны Ерөнхийлөгчийг сонгох, чөлөөлөх;
  - 4.4.4 “Нийгмийн ардчилал” МОХ-ны Ерөнхийлөгчийн тайлан илтгэлийг сонсох, хэлэлцэх;
  - 4.4.5 “Нийгмийн ардчилал” МОХ-ны Бага хурлын гишүүдийг сонгох, чөлөөлөх;
  - 4.4.6 “Нийгмийн ардчилал” МОХ-ны Хяналтын хорооны гишүүдийг сонгох, чөлөөлөх;
  - 4.4.7 “Нийгмийн ардчилал” МОХ-ны Хяналтын хорооны тайлан илтгэлийг сонсох, хэлэлцэх;
  - 4.4.8 “Нийгмийн ардчилал” МОХ-г өөрчлөн байгуулах, татан буулгах;
  - 4.4.9 “Нийгмийн ардчилал” МОХ-ны бусад асуудал;
- 4.5 Их хурлын тов, гишүүдийн тоо, тэдгээрийг сонгох журмыг Бага хурлаас тогтооно.
- 4.6 Их хурлын саналын эрхтэй нийт төлөөлөгчдийн энгийн олонхи хүрэлцэн ирснээр хурал хүчин төгөлдөр болно.
- 4.7 Энэхүү дүрмийн 4.4.8-д заасан асуудлыг Их хурлын нийт гишүүдийн дийлэнхи олонхийн саналаар, бусад асуудлыг Их хуралд оролцож буй нийт гишүүдийн энгийн олонхийн саналаар шийдвэрлэж, шийдвэрийг тогтоол хэлбэрээр гаргана.

#### **5 дугаар зүйл. “Нийгмийн ардчилал” МОХ-ны Бодлогын зөвлөл**

- 5.1 “Нийгмийн ардчилал” МОХ нь Бодлогын зөвлөлтэй байна. /цаашид Бодлогын зөвлөл гэх/
- 5.2 Бодлогын зөвлөл нь 9 хүртлэх гишүүдийн бүрэлдэхүүнтэй байна.
- 5.3 Бодлогын зөвлөл нь “Нийгмийн Ардчилал” МОХ-нд Ерөнхийлөгч, Ерөнхий нарийн бичгийн дарга, Дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан гишүүдийн төлөөллөөс бүрдэнэ.
- 5.4 Бодлогын зөвлөлийн гишүүдийг “Нийгмийн Ардчилал” МОХ-ны Удирдах зөвлөлийн хурлаас батална.
- 5.5 Бодлогын зөвлөлийн дарга нь “Нийгмийн Ардчилал” МОХ-ны эрхээ хэрэгжүүлж буй Ерөнхийлөгчийн өмнөх Ерөнхийлөгч байна.
- 5.6 Бодлогын зөвлөл нь “Нийгмийн Ардчилал” МОХ-нд улс төрийн дэмжлэг үзүүлж зөвлөмж өгнө.

#### **6 “Нийгмийн ардчилал” МОХ-ны Ерөнхийлөгч**

- 6.1 “Нийгмийн ардчилал” МОХ-ны Ерөнхийлөгч /цаашид “Ерөнхийлөгч” гэх/ “Нийгмийн ардчилал” МОХ-ны удирдагч мөн.
- 6.2 Ерөнхийлөгч 4 жилээр сонгогдон ажиллах ба улиран сонгогдохгүй.
- 6.3 Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хугацаанд зөвлөлтэй байж болно.
- 6.4 Монгол Ардын Намын дарга Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх, чөлөөлөх саналыг Их хуралд оруулна.
- 6.5 Ерөнхийлөгчийн сонгуулийгилээр санал хурааж сонгоно.
- 6.6 Ерөнхийлөгч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 6.6.1 “Нийгмийн ардчилал” МОХ-ны Их хурлаас тодорхойлсон үзэл баримтлал, бодлогыг удирдан хэрэгжүүлэх;
  - 6.6.2 “Нийгмийн ардчилал” МОХ-ны Бага хурал, Удирдах зөвлөлийн хурлыг удирдах;
  - 6.6.3 Их хурлын хооронд “Нийгмийн ардчилал” МОХ-ны үйл ажиллагааг удирдах;
  - 6.6.4 Шаардлагатай тохиолдолд ээлжит болон ээлжит бус Их хурлыг зарлан хуралдуулах саналыг бага хуралд, бага хурал, аймаг, нийслэл, дүүргийн ээлжит бус чуулганыг хуралдуулах тухай саналыг Удирдах зөвлөлд оруулах;
  - 6.6.5 “Нийгмийн ардчилал” МОХ-ны Бага хурлын гишүүдийг нэр дэвшүүлэх, чөлөөлөх саналыг оруулах;
  - 6.6.6 “Нийгмийн ардчилал” МОХ-ны Дэд ерөнхийлөгчид, Ерөнхий нарийн бичгийн дарга, Удирдах зөвлөлийн гишүүдийн нэр дэвшүүлэх, чөлөөлөх саналыг оруулах;
  - 6.6.7 “Нийгмийн ардчилал” МОХ-ны аймаг, нийслэл, салбарын Тэргүүнийг тухайн аймаг, нийслэл, Монгол Ардын Намын хороотой зөвшилцөн чуулганд нэр дэвшүүлэх, чөлөөлөх саналыг оруулах;
  - 6.6.8 Дэд ерөнхийлөгч, салбарын дарга нартай үр дүнгийн гэрээ байгуулах;

- 6.6.9 “Нийгмийн ардчилал” МОХ-г дотоод, гадаадад бүрэн эрхтэйгээр төлөөлөх;
- 6.6.10 Монгол Ардын Намын үйл ажиллагаанд “Нийгмийн ардчилал” МОХ-ны байр суурийг илэрхийлэх, хүний нөөцийн асуудлаар Монгол Ардын Намын удирдлагад санал оруулах;
- 6.6.11 Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хамаарах болон “Нийгмийн ардчилал” МОХ-ны үйл ажиллагаанд холбогдох асуудлаар тушаал гаргах, тусгайлсан ажлын хэсэг байгуулах, биелэлтийг хянах;

## **7 дугаар зүйл. “Нийгмийн ардчилал” МОХ-ны Бага хурал**

- 7.1 “Нийгмийн ардчилал” МОХ-ны Бага хурал нь /цаашид “Бага хурал” гэх/Их хурлын хооронд “Нийгмийн ардчилал” МОХ-ны зорилго, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох эрх бүхий байгууллагамөн.
- 7.1 Бага хурал нь нийт 121 хүртэл гишүүнтэй байна.
- 7.2 Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчид, Ерөнхий нарийн бичгийн дарга, аймаг, нийслэл, дүүргийн салбар холбооны Тэргүүнүүд Бага хурлын гишүүн байна.
- 7.3 Бага хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 7.3.1 Их хурлын хооронд “Нийгмийн ардчилал” МОХ-ны зорилго, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох;
  - 7.3.2 Ерөнхийлөгчийн санал болгосны дагуу ээлжит болон ээлжит бус Их хурлын товыг зарлах;
  - 7.3.3 Бага хурлын гишүүнийг нөхөнсонгох, чөлөөлөх;
  - 7.3.4 Дэд ерөнхийлөгчид, Ерөнхий нарийн бичгийн дарга, Удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх;
  - 7.3.5 Удирдах зөвлөлийн тайлан илтгэлийг жил, хагас жил, улирлаар сонсох, хэлэлцэх, чиглэл өгөх;
- 7.4 Бага хурал нь жилд 1-ээс доошгүй удаа хуралдана.
- 7.5 Бага хурлын гишүүдийн олонхийн саналаар Бага хурлыг хуралдуулах саналыг гаргаж болно.
- 7.6 Бага хурлын гишүүдийн энгийн олонхи хүрэлцэн ирснээр хурал хүчин төгөлдөр болох ба хурлын шийдвэр тогтоол хэлбэрээр гарна.
- 7.7 Хуралд оролцсон төлөөлөгчдийн энгийн олонхийн саналаар аливаа асуудлыг шийдвэрлэнэ.
- 7.8 “Нийгмийн ардчилал” МОХ-ны Дэд ерөнхийлөгчид
  - 7.8.1 “Нийгмийн ардчилал” МОХ арав хүртэл Дэд ерөнхийлөгчтэй байна.
  - 7.8.2 Дэд ерөнхийлөгчийн хэрэгжүүлэх ажлын чиг үүрэг, түүнтэй холбогдох харилцааг тогтооно.
  - 7.8.3 6.6.8 дахь заалтыг жилд нэг удаа дүгнэх;
- 7.9 “Нийгмийн ардчилал” МОХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга
  - 8.7.1 “Нийгмийн ардчилал” МОХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга /цаашид “Ерөнхий нарийн бичгийн дарга” гэх/ нь “Нийгмийн ардчилал” МОХ-ны өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулна.
  - 8.7.2 Хөрөнгө, санхүү, аж ахуйг эрхлэн хөтлөх, батлагдсан төсвийг захиран зарцуулах;
  - 8.7.3 Архив, албан хэрэг хөтлөлтийг зохих журмын дагуу эрхлэн хөтлөх;
  - 8.7.4 Ажлын албаны орон тооны ажилтнуудыг Ерөнхийлөгчтэй зөвшилцөж томилож ажиллуулах, ажлаас чөлөөлөх;

## **8 дугаар зүйл. “Нийгмийн ардчилал” МОХ-ны Удирдах зөвлөл**

- 8.1 “Нийгмийн ардчилал” МОХ-ны Удирдах зөвлөл /цаашид “Удирдах зөвлөл” гэх/ нь “Нийгмийн ардчилал” МОХ-ны гүйцэтгэх төв байгууллага болно.
- 8.1 Удирдах зөвлөл нь Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчид, Ерөнхий нарийн бичгийн дарга, Нарийн бичгийн дарга нарыг оролцуулан нийт 39 хүртэл гишүүнтэй байна.
- 8.2 Удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 8.2.1 Удирдах зөвлөл нь Их хурал, Бага хурлаас тодорхойлсон бодлого зорилт, хөтөлбөр төлөвлөлтийг хэрэгжүүлэх;
  - 8.2.2 Ерөнхий нарийн бичгийн даргын тайлан, үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийг сонсох, хэлэлцэх;
  - 8.2.3 Ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, орон тоог батлах;
  - 8.2.4 Ажлын албаны жилийн төсөв, төлөвлөгөөг батлах, түүний биелэлтийг хянах;
  - 8.2.5 Бага хурлыг товлон зарлах;
  - 8.2.6 Удирдах зөвлөл нь өөрийн чиг үүрэгт хамаарах асуудлаар шийдвэр гаргах;
  - 8.2.7 Бусад асуудал;
- 8.3 Удирдах зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана.
- 8.4 Удирдах зөвлөлийн хуралд гишүүдийн олонхи хүрэлцэн ирснээр хурал хүчин төгөлдөр болох бөгөөд аливаа асуудлыг хуралд оролцож байгаа гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

## **9 дүгээр зүйл. “Нийгмийн ардчилал” МОХ-ны салбар холбоо**

- 9.1 “Нийгмийн ардчилал” МОХ аймаг, нийслэл, дүүргийн салбартай байх ба тэдгээр нь нутаг дэвсгэрийн нэгжийн дагуу байгуулагдана. Тухайн орон нутаг дахь Монгол Ардын Намын хороог түшиглэн салбарыг зохион байгуулна.

- 9.2 Тухайн аймаг, нийслэл, дүүргийн салбарын эрх барих дээд байгууллага нь Чуулган байна. Чуулган нь 2 жилд 1 удаа хуралдах бөгөөд ээлжит бус чуулганыг зарлан хуралдуулж болно.
- 9.3 Аймаг, нийслэл, дүүргийн чуулган нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 9.3.1 Их хурлаас тодорхойлсон үзэл баримтлал, бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох;
- 9.3.2 6.6.8 дахь заалтыг 2 жилд нэг удаа дүгнэх;
- 9.3.3 Аймаг, нийслэл, дүүргийн салбарын Тэргүүнийг сонгох, чөлөөлөх;
- 9.3.4 Аймаг, нийслэл, дүүргийн салбарын Тэргүүний тайлан илтгэлийг сонсох, хэлэлцэх;
- 9.3.5 Аймаг, нийслэл, дүүргийн салбарын Тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнийг сонгох, чөлөөлөх;
- 9.3.6 Тухайн салбарт хамаарах бусад асуудал
- 9.4 “Нийгмийн ардчилал” МОХ-ны аймаг, нийслэл, дүүргийн салбарын Тэргүүн нь тухайн салбарын удирдагч мөн.
- 9.5 “Нийгмийн ардчилал” МОХ-ны аймаг, нийслэл, дүүргийн салбарын Тэргүүн дараахи эрх, үүрэгтэй. Үүнд:
- 9.5.1 Тухайн салбарын үйл ажиллагааг зохион байгуулах, удирдлагаар хангах;
- 9.5.2 Чуулган болон тэргүүлэгчдийн хурлыг даргалах;
- 9.5.3 Тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнийг чуулганд нэр дэвшүүлэх;
- 9.5.4 Дэд тэргүүн, нарийн бичгийн дарга нарыг сонгуулахаар Тэргүүлэгчдийн хуралдаанд нэр дэвшүүлэх;
- 9.5.5 Бүрэн эрхийнхээ хугацаанд Бага хуралд сонгогдох;
- 9.5.6 Тухайн салбараа дотоод, гадаадад бүрэн эрхтэйгээр төлөөлөх;
- 9.6 “Нийгмийн ардчилал” МОХ-ны Аймаг, нийслэл, дүүргийн тэргүүлэгчид 25 хүртэл гишүүнтэй байна.
- 9.7 “Нийгмийн ардчилал” МОХ-ны аймаг, нийслэл, дүүргийн салбарын тэргүүлэгчид дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 9.7.1 Чуулган хооронд тухайн салбарын үйл ажиллагааны зорилго, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох;
- 9.7.2 Тухайн салбарын жилийн төсөв, төлөвлөгөөг батлах, биелэлтийг хянах;
- 9.7.3 Тэргүүний санал болгосоны дагуу чуулганыг товлон зарлах;
- 9.7.4 Тэргүүлэгч гишүүнийг нөхөн сонгох, чөлөөлөх;
- 9.7.5 Дэд тэргүүн, нарийн бичгийн даргыг сонгох, чөлөөлөх;
- 9.7.6 Салбарын ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, орон тоог батлах;
- 9.7.7 Бусад асуудал
- 9.8 Тэргүүлэгчдийн хурал улиралд нэгээс доошгүй удаа хуралдана.
- 9.9 “Нийгмийн ардчилал” МОХ гадаад улс, хотод салбартай байж болно. Салбар байгуулах болон салбарын зохион байгуулалтын бүтэц, ажиллах журмыг “Нийгмийн ардчилал” МОХ-ны Удирдах зөвлөлөөс батлана.

#### **10 дугаар зүйл. “Нийгмийн ардчилал” МОХ-ны дэргэдэх зөвлөл**

- 10.1 “Нийгмийн ардчилал” МОХ нь Их, дээд сургууль, коллеж, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүд болон оюутны дотуур байруудыг түшиглэн дэргэдээ зөвлөл байгуулж болно.
- 10.2 “Нийгмийн ардчилал” МОХ нь гадаадад суралцагч Монгол оюутнуудын дунд салбар зөвлөлийг байгуулж болно.
- 10.3 “Нийгмийн ардчилал” МОХ-ны дэргэдэх зөвлөлийн зохион байгуулалтын бүтэц, ажиллах журмыг “Нийгмийн Ардчилал” МОХ-ны Удирдах зөвлөлөөс батална.

#### **11 дүгээр зүйл. “Нийгмийн ардчилал” МОХ-ны Хяналтын хороо**

- 11.1 “Нийгмийн ардчилал” МОХ-ны Хяналтын хороо/цаашид “Хяналтын хороо” гэх/ нь “Нийгмийн ардчилал” МОХ-ны өөрийн дотоод хяналтын сонгуульд байгууллага бөгөөд Монгол Улсын хууль, тогтоомж болон энэхүү дүрмийн хүрээнд “Нийгмийн ардчилал” МОХ-ны үйл ажиллагаа, санхүүжилт, дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавих үүргийг хараат бусаар хэрэгжүүлнэ.
- 11.1 Хяналтын хорооны бүрэлдэхүүнийг Их хурлаас илээр санал хурааж сонгоно.
- 11.2 Хяналтын хороо нь 9 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба Хяналтын хорооны даргыг гишүүд дотроосоо сонгоно.
- 11.3 Хяналтын хороо нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 11.3.1 “Нийгмийн ардчилал” МОХ-ны үзэл баримтлал, бодлого, дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавих, дүгнэлт гаргах;
- 11.3.2 “Нийгмийн ардчилал” МОХ-ны өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх;
- 11.3.3 Иргэд, дэмжигчдээс гаргасан санал, гомдлыг хянан шийдвэрлэх;
- 11.3.4 Шаардлагатай тохиолдолд “Нийгмийн ардчилал” МОХ-ны үйл ажиллагааны талаар Ерөнхийлөгч, Бага хурал, Удирдах зөвлөлд мэдээлэх, Хяналтын хорооны дүгнэлт, шийдвэрийг хүргүүлэх;
- 11.4 Салбарын бүтэцэд хяналтын зөвлөл ажиллуулж болно.
- 11.5 Хяналтын хороо хяналтын зөвлөлийг арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.
- 11.6 Хяналтын хороо энэхүү дүрэмд нийцүүлэн ажиллах журмаа батлаж мөрдөнө. Хяналтын зөвлөл нэгдсэн нэг журмыг үйл ажиллагаандаа баримтлан ажиллана.

**12 дүгээр зүйл. “Нийгмийн ардчилал” МОХ-ны өмч хөрөнгө**

12.1 “Нийгмийн ардчилал” МОХ-ны өмч хөрөнгө нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

12.1.1 “Нийгмийн ардчилал” МОХ-ны өмчлөлийн оюуны болон материаллаг хөрөнгө;

12.1.2 Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааны орлого;

12.1.3 Байгууллага, аж ахуй нэгж, дэмжигч иргэний хандив;

12.1.4 Сонгуульт гишүүдийн татвар, хандив;

12.2 “Нийгмийн ардчилал” МОХ нь өмч хөрөнгөө дүрмийн зорилгоо хэрэгжүүлэх чиглэлээр ашиглана.

**13 дүгээр зүйл. “Нийгмийн ардчилал” МОХ-г өөрчлөн байгуулах, татан буулгах**

13.1 “Нийгмийн ардчилал” МОХ-г өөрчлөн байгуулсан, татан буулгасан тохиолдолд үүсэх харилцааг Монгол Улсын хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

13.1 “Нийгмийн ардчилал” МОХ өөрчлөн байгуулагдсан эсвэл татан буугдсан тохиолдолд түүний хариуцвал зохих төлбөрийг хийсний дараа үлдсэн хөрөнгийг түүний үйл ажиллагааг залгамжилсан байгууллага эсвэл дүрэмд нийцсэн үйл ажиллагаанд зарцуулна.